



“ИХМОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ” ХХК
НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, АУДИТ БИЗНЕС ЗӨВЛӨГӨӨ

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2 дугаар хороо,
Төмөрчний гудамж, 8 дугаар байр, 1003 тоот
Утас: (+976) 7000 – 1778, Утас: (+976) 7000 – 1778,
И-мэйл: info@imkaudit.mn, Веб хуудас: www.imkaudit.mn

Г “ХӨСӨГ ТРЕЙД” ХК-ИЙН
УДИРДЛАГАД

2024/09/25 № 9/2024/21

Танай _____-ны № _____-г

Г **ХАРААТ БУС АУДИТОРЫН**
ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Бид “Хөсөг Трейд” ХК (цаашид “Компани”гэх)-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөр тасалбар болгосон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн бодлогуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөр тасалбар болгосон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан эдгээр санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд, Компанийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болгосон тайлант жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн, шударгаар толилуулсан байна гэж дүгнэж байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (“АОУС”)–ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт тайлбарласан. Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөл (НБЭЗОУСЗ)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Аудитын тухай Монгол улсын хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу Бид компаниас хараат бус бөгөөд хууль болон НБЭЗОУСЗ-өөс гаргасан дүрмийн шаардлагын дагуу тавигддаг ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж найдаж байна.

Санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэж, толилуулах нь компанийн удирдлагын үүрэг болно. Энэхүү үүрэг хариуцлагад санхүүгийн тайлангуудыг залилан юм уу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийлэлгүйгээр бэлтгэж, шударгаар толилуулахтай холбоотой дотоод хяналтын системийг зохиож, хэрэгжүүлэн, түүнийгээ тууштай ажиллуулах, нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой бодлогуудыг сонгож, хэрэглэх, нөхцөл байдалд тохируулан нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудыг хийх зэрэг зүйлс багтана.

Аудиторын үүрэг хариуцлага

Бидний үүрэг хариуцлага бол гүйцэтгэсэн аудитдаа тулгуурлан эдгээр санхүүгийн тайлангуудад дүгнэлт гаргах явдал юм. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэдэг.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

Эдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудыг баримталж, санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн эсэх талаар ул үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг биднээс шаарддаг. Аудитын үед санхүүгийн тайлангууд дахь дүн болон тодруулгын талаар аудитын нотолгоо олж авахад чиглэгдсэн горимуудыг гүйцэтгэсэн. Эдгээр горимуудыг аудиторын шийдэлд суурилан сонгодог бөгөөд үүнд, залилан юм уу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн тооцоолол багтдаг. Эдгээр эрсдэлийн тооцооллыг хийхтэй холбоотойгоор, аудитор компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд нь дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирсон аудитын горимыг сонгож хэрэглэх зорилгоор компанийн санхүүгийн тайланг бэлтгэж, шударгаар толилуулахад зориулан хэрэглэж байгаа дотоод хяналтыг авч үздэг. Мөн санхүүгийн тайлагналыг бүхэлд нь үнэлэхээс гадна, удирдлагын зүгээс хийсэн томоохон тооцооллуудын үндэслэлтэй байдал, хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын тохиромжтой байдлыг үнэлэх ажлыг бидний аудит багтаасан. Бидний гүйцэтгэсэн аудит нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоогоор хангагдсан гэж бид итгэж байна.

Хэрэглээний хязгаарлалт

Энэхүү тайлан нь Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох хувьцаа эзэмшигчийн хүсэлтийн дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулагдсан ба аливаа нэгэн өөр зорилго агуулаагүй болно.

Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд бусад этгээдийн өмнө үүрэг хариуцлага хүлээхгүй болно.

Бусад хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагын талаарх тайлан

Түүнчлэн, санхүүгийн тайланг бэлтгэхдээ Монгол улсад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн зарчмууд болон Сангийн Сайдын тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн заавартай нийцэж байна.

ИХМОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК

Мэргэшсэн нягтлан бодогчид

Улаанбаатар хот, Монгол Улс

Огноо: 2024 оны 03 дүгээр сарын 25



Захирал

ХӨСӨГ ТРЕЙД ХК

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн

Санхүү байдлын тайлан

Үзүүлэлт	Тодруулга	/төгрөгөөр/	
		2022.12.31.	2023.12.31.
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	7	294,911,421.32	6,630,896.92
Дансны авлага	8	19,600,000.00	45,853,295.19
Бараа материал	9	2,418,036.37	1,207,818.18
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	10	-	373,630,556.00
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө	-	-	1,210,218.19
Эргэлтийн хөрөнгийн дүн		316,929,457.69	428,532,784.48
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	12	977,127,684.56	445,213,432.23
Биет бус хөрөнгө	11	543,000.00	403,805,501.94
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		977,670,684.56	849,018,934.17
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		1,294,600,142.25	1,277,551,718.65
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ			
Дансны өглөг	13	5,814,034.86	139,926,563.59
Цалингийн өглөг		271,000.00	-
Татварын өр	14	433,250.02	1,873,797.70
Богино хугацаат өр төлбөрийн дүн		6,518,284.88	141,800,361.29
Бусад урт хугацаат өр төлбөр	20	386,578,229.49	359,690,010.49
Урт хугацаат өр төлбөрийн дүн		386,578,229.49	359,690,010.49
Өр төлбөрийн дүн		393,096,514.37	501,490,371.78
Өмч Хувийн	19	29,579,300.00	29,579,300.00
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		904,000,000.00	904,000,000.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц			

ХӨСӨГ ТРЕЙД ХК

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн

Эздийн өмчийн бусад хэсэг		6,240,000.00	6,240,000.00
Хуримтлагдсан ашиг	19	(38,315,672.12)	(163,757,953.13)
Эздийн өмчийн дүн		901,503,627.88	776,061,346.87
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН		1,294,600,142.25	1,277,551,718.65

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн бүрдэл хэсэг болно.

ХӨСӨГ ТРЕЙД ХК

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн

Орлогын дэлгэрэнгүй тайлан

Үзүүлэлт	Тодруулга	/төгрөгөөр/	
		2022.12.31.	2023.12.31.
Борлуулалтын орлого	21	-	62,272,727.28
Борлуулалтын өртөг	22	-	-
Нийт ашиг/алдагдал		-	62,272,727.28
Түрээсийн орлого		179,256,900.00	-
Хүүний орлого	24.1	-	4,307,931.17
Ногдол ашгийн орлого			
Бусад орлого		47,494,800.00	58,029,698.99
Борлуулалт маркетингийн зардал	23	324,295,500.00	249,604,164.62
Ерөнхий ба удирдлагын зардал	23	-	-
Санхүүгийн зардал		-	-
Бусад зардал	24.2	26,615,900.00	17,680.70
Гадаад валютын ханшийн зөрүүний олз/гарз		-	-
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		-	-
Бусад ашиг (алдагдал)			-
Татвар төлөхийн өмнөх ашиг/алдагдал		(124,159,700.00)	(125,011,487.88)
Орлогын албан татвар	18	-	430,793.13
Татварын дараах ашиг/алдагдал		(124,159,700.00)	(125,442,281.01)

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн бүрдэл хэсэг болно.

ХӨСӨГ ТРЕЙД ХК

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн

Өмчийн Өөрчлөлтийн Тайлан

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2021 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	29,579,300.00	904,000,000.00	6,240,000.00	97,291,527.88	126,870,827.88
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны загроулга	-	-	-	(11,447,500.00)	(11,447,500.00)
Залруулсан үлдэгдэл	29,579,300.00	904,000,000.00	6,240,000.00	85,844,027.88	115,423,327.88
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(124,159,700.00)	(124,159,700.00)
2022 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	29,579,300.00	904,000,000.00	6,240,000.00	(38,315,672.12)	901,503,627.88
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны загроулга	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	29,579,300.00	904,000,000.00	6,240,000.00	(38,315,672.12)	901,503,627.88
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(125,442,281.01)	(125,442,281.01)
2023 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	29,579,300.00	904,000,000.00	6,240,000.00	(163,757,953.13)	776,061,346.87

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн бүрдэл хэсэг болно.

ХӨСӨГ ТРЕЙД ХК

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн

Мөнгөн Гүйлгээний Тайлан

Үзүүлэлт	2022.12.31.	/төгрөгөөр/ 2023.12.31.
Мөнгөн орлогын дүн	256,312,000.00	238,328,239.69
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	222,785,000.00	106,079,373.69
Бусад мөнгөн орлого	33,527,000.00	132,248,866.00
Мөнгөн зарлагын дүн	253,283,878.68	530,456,295.26
Ажиллагчдад төлсөн	38,611,878.68	271,040.00
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	10,393,000.00	-
Бараа материал авахад төлсөн	25,873,200.00	-
Ашиглалтын зардалд төлсөн	47,916,600.00	77,673,577.75
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	236,400.00	-
Татварын байгууллагад төлсөн	110,683,500.00	448,913,877.08
Бусад мөнгөн зарлага	19,569,300.00	3,597,800.43
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	3,028,121.32	(292,128,055.57)
Мөнгөн орлогын дүн	-	4,307,931.17
Хүлээн авсан хүүний орлого	-	4,307,931.17
Мөнгөн зарлагын дүн	1,500,000.00	-
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,500,000.00	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,500,000.00)	4,307,931.17
Мөнгөн орлогын дүн	-	-
Мөнгөн зарлагын дүн	-	460,400.00
Бусад	-	460,400.00
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	(460,400.00)
Валютын ханшны зөрүү	-	-
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,528,121.32	(288,280,524.40)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	293,383,300.00	294,911,421.32
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	294,911,421.32	6,630,896.92

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн бүрдэл хэсэг болно.

ХӨСӨГ ТРЕЙД ХК

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн Санхүүгийн Тайлангийн Тодруулга

1 Компанийн талаарх мэдээлэл

"Хөсөг Трейд" ХК Компанийн үндэс суурь анх угсармал орон сууцны ажлыг эрчимжүүлэх байгууллагын харьяа автобааз болох "Техниктүслалцааны угсармал орон сууцны барилга трест" нэртэйгээр үйл ажиллагаа явуулж байсан бөгөөд Засгийн газрын өмч хувьчлалын комиссын 1991 оны 12-р сарын 14-ны өдрийн 32-р тогтоолоор "Хөсөг трейд" ХК болж өөрчлөн байгуулагдав.

Компанийн хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг 20 дугаар хороо, Дунд гол Өөрийн байр. Утас: (976)-9911-0972

Компанийн улсын бүртгэлийн дугаар: 9010001052, Регистр: 2037467

Хөсөг Трейд ХК нь Улсын бүртгэлийн гэрчилгээнд "Автомашин засвар үйлчилгээ", "Гадаад худалдаа", "Цайны газар" "Зочид буудал" эрхлэхээр бүртгүүлсэн бөгөөд 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 02 тоот тогтоолын 1 дүгээр хавсралтаар компанийн шинэчлэгдсэн дүрэмд дараах үйл ажиллагааг эрхлэхээр заасан байна. Үүнд:

- Үл хөдлөх хөрөнгийн түрээсийн үйл ажиллагаа эрхлэх
- Компани нь үндсэн үйл ажиллагаатай холбоотой хуулиар хориглоогүй бусад ажил, үйлдвэрлэл үйлчилгээ явуулж болно гэж заасан байна.

Компанийн дүрмийн сан нь нэг бүр нь 100 төгрөгийн үнэтэй 295,793 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэж байна. Хувьцааны тоо ширхэг болон хувьцаа эзэмшигчдийн бүтэц дараах байдалтай байна.

Нэр	Хувьцаа эзэмшигчдийн		Хувьцаа эзэмшлийн	
	Аж ахуйн нэгж иргэний тоо	Татвар төлөгчийн дугаар	Тоо	Хувь
О.Дамжин	1	0072080875	2,338	0.8%
С.Жавзан-Орлом	1	0072111366	51,974	17.6%
Эй Ди ЭмЭм Ди ХХК	1	5984599	96,357	32.6%
Д.Бадам	1	0076051964	88,118	29.8%
Г.Маргад	1	УИ96040618	53,916	18.2%
Бусад	79	-	3,090	1.0%
НИЙТ ДҮН	84		295,793	100.0%

2 Компанийн үйл ажиллагааны орчин

Монгол улсын эдийн засаг нь хөгжиж байгаа эдийн засаг юм. Энэ нь тус улсын эдийн засгийн нөхцөл байдал нь зэсийн болон нүүрсний үнээс ихээхэн хамааралтай. Хууль эрх зүй, татварын зохицуулалтын орчин үргэлжлэн хөгжиж, байнга өөрчлөгдөж, холбогдох журам заавар өөрчлөгдөж байна.

Монгол Улсын татвар, валютын ханш, гаалийн хууль тогтоомж тогтвортой хэдий ч, гадаад худалдааны нөхцөл хурдтай хувирч байна. Монгол Улсын эдийн засгийн цаашдын гүйцэтгэл нь БНХАУ-ын эрэлтийн тасралтгүй байдал, дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнийн тогтворгүй байдал зэрэгтэй шууд холбоотой бөгөөд Засгийн газраас авч хэрэгжүүлж буй эдийн засаг, санхүү, мөнгөний арга хэмжээний үр нөлөө, татвар, хууль эрх зүйн зохицуулалт, улс төрийн үйл явцаас хамаарна. Дэлхийн эдийн засгийн өнөөгийн тодорхойгүй байдал, санхүүгийн зах зээлийн тогтворгүй байдал, дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнийн тогтворгүй байдал, Монголын эдийн засгийн өсөлт удаахрах, төгрөгийн ам.доллар, юаньтай харьцах ханшийн сулрал болон бусад болзошгүй эрсдэлүүд нь Монгол улсын болон компанийн санхүүгийн нөхцөлд ихээхэн сөрөг нөлөө үзүүлж болзошгүй юм. Ирээдүйн эдийн засаг, зохицуулалтын нөхцөл байдал нь удирдлагын одоогийн хүлээлтээс өөр байж болно.

Удирдлага нь компанийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, ажилчдаа дэмжих чиглэлээр шаардлагатай арга хэмжээг авч байна. Гэсэн хэдий ч өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдлын ирээдүйн үр нөлөөг урьдчилан таамаглахад хэцүү бөгөөд удирдлагын одоогийн хүлээлт, тооцоолол нь бодит үр дүнгээс ялгаатай байж болно.

3 Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд

3.1 Тайлан бэлтгэх үндэслэл

Компанийн санхүүгийн тайлангууд нь НББОУСЗ-өөс гаргасан СТОУС-ын дагуу бэлтгэгдсэн. Санхүүгийн тайлан дахь дүнгүүдийг түүхэн өртгийн зарчмаар бэлтгэсэн болно. Санхүүгийн тайлан дахь дүнгүүдийг Компанийн үйл ажиллагааны мөнгөн тэмдэгт болох Монгол улсын мөнгөн тэмдэгт

ХЭСӨГ ТРЕЙД ХК

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн Санхүүгийн Тайлангийн Тодруулга

төгрөгөөр толилуулсан. Санхүүгийн тайлан дахь дүнгүүдийг тодруулгад өөрөөр зааснаас бусад тохиолдолд төгрөгөөр тайлагнасан.

3.2 Хэмжүүрийн суурь

Санхүүгийн тайланг холбогдох тодруулгад тусгайлан зааснаас бусад зүйлсийн хувьд түүхэн өртгийн зарчимд үндэслэн бэлтгэсэн.

3.3 Бүртгэлийн ба толилуулгын валют

Энэхүү санхүүгийн тайланг бэлтгэж, тайлагнахдаа "Хөсөг Трейд" ХК нь бүртгэлийн валют буюу компанийн үйл ажиллагаа эрхэлж буй эдийн засгийн орчны үндсэн валют болох Монгол Улсын мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлсэн. Бүх дүнг төгрөгөөр толилуулсан.

3.4 Тасралтгүй байх зарчим

Санхүүгийн тайланг удирдлага зохистой гэж үзсэний дагуу тасралтгүй байх зарчмын дагуу бэлтгэсэн. 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Хөсөг Трейд ХК-ийн эргэлтийн хөрөнгийн дүн нь богино хугацаат өр төлбөрийн дүнгээс 707,218,572.88 төгрөгийн илүүдэлтэй бөгөөд 359,690,010.49 төгрөгийн урт хугацаат зээлтэй байна.

3.5 Таамаглал, тооцоолол ба үнэлгээ хэрэглэх нь

Санхүүгийн тайланг СТОУС-д нийцүүлэн бэлтгэх үйл явц нь таамаглал тооцоолол, үнэлгээ хэрэглэхийг удирдлагаас шаарддаг ба энэхүү таамаглал, тооцоолол, үнэлгээ нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилт, мөн хөрөнгө, өр төлбөр, орлого зардлын зүйлсийн дүнг тодорхойлоход нөлөөлдөг. Гүйцэтгэлээрх үр дүн нь эдгээр тооцооллоос зөрүүтэй байж болно.

Компани санхүүгийн тайланг бэлтгэхдээ тухайн үеийн боломжит таамаглал, тооцоолол дээр суурилсан. Одоогийн нөхцөл байдал болон ирээдүйн таамаглал нь зах зээлийн өөрчлөлт эсвэл компанийн хяналтаас гадуурх үйл ажиллагаанаас хамаарч өөрчлөгдөж болзошгүй. Үүнтэй холбоотойгоор аливаа өөрчлөлтүүд тохиолдсон даруйдаа таамаглалын суурь болон тооцоололд тусгагддаг.

Дараа жилийн санхүүгийн тайланд материаллаг залруулга хийх эрсдэл учруулахуйц таамаглал болон тооцооллын тодорхой буюу асуудлын талаарх мэдээллийг доор дурдсан тодруулгын хэсэгт багтаасан.

3.5.1 Үндсэн хөрөнгийн ашиглагдах хугацаа

Компанийн удирдлага нь үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон холбогдох элэгдлийн зардлыг тооцоолдог. Энэхүү тооцооллыг ижил шинж чанар, үүрэгтэй хөрөнгийн бодит ашиглалтын хугацаанд суурилан хийдэг. Энэ нь техник технологийн томоохон шинэчлэл, өрсөлдөгчдийн салбарын хөдөлгөөнд үзүүлж буй хариу үйлдлийн үр дүнд их хэмжээгээр өөрчлөгдөж болно. Удирдлага өнөөгийн тооцоолсон ашиглалтын хугацаа нь өмнө нь тооцоолсон ашиглалтын хугацаанаас бага гэж үзвэл элэгдлийн зардлыг нэмэгдүүлж, эсвэл техник болон стратегийн хувьд хоцрогдсон, хаягдсан эсвэл борлуулсан хөрөнгийг данснаас хасаж эсвэл үнэ цэнийг бууруулдаг. Компанийн хөрөнгийн ашиглах хугацааг хэрхэн тодорхойлсныг Тодруулга 6.9-с харна уу.

3.5.2 Бараа материалын цэвэр боломжит үнэ цэнийг тооцоолох

Компани нь тайлант хугацааны эцэст бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнэ цэний аль багаар нь хэмжинэ. Цэвэр боломжит үнэ цэнэ гэж бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад бараа материалыг худалдан борлуулахаар тооцоолж буй үнээс түүнийг борлуулахад шаардагдах тооцсон зардлыг хассан дүн юм. Гэмтэлтэй, хоцрогдсон болон удаан хугацаанд хөдөлгөөнд ороогүй бараа материал байгаа эсэхийг удирдлагын зүгээс тогтмол хянадаг.

Компани өөрийн тооцооллыг үнэн зөв, бодитой гэж үзэж байгаа боловч аливаа бодит нөхцөл байдал эсвэл нөлөө бүхий хүчин зүйлсээс шалтгаалан тооцоололд өөрчлөлт орсон тохиолдолд ашиг, алдагдал болон өмчид материаллагаар нөлөө үүсэж болзошгүй.

3.5.3 Бодит үнэ цэний хэмжилт

Компани нь хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийг тодорхойлохдоо тухайн зах зээл дээрх хамгийн сайн ажиглагдахуйц мэдээллийг ашиглахыг зорьдог. Бодит үнэ цэнийг үнэлгээний арга барилд ажиглагдах өгөгдлүүдэд үндэслэн бодит үнэ цэний шатлалаар дараах түвшинд ангилдаг:

- Түвшин 1: Ижил төстэй хөрөнгө, өр төлбөрийн идэвхтэй зах зээлийн жишиг үнэ (тохируулагдаагүй).

ХӨСӨГ ТРЕЙД ХК

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн Санхүүгийн Тайлангийн Тодруулга

- Түвшин 2: Түвшин 1 дэх идэвхтэй зах зээл дээрх хөрөнгө, өр төлбөрийн жишиг үнээс бусад шууд (жишээлбэл: үнэ) болон шууд бусаар (жишээлбэл: үнээс хамааралтай) ажиглаж болох өгөгдлүүд.
- Түвшин 3: Ажиглаж болох зах зээлийн өгөгдөлд үндэслээгүй хөрөнгө, өр төлбөрийн өгөгдөл (ажиглаж болохооргүй өгөгдлүүд)

Хэрэв бодит үнэ цэний шатлалын түвшин хооронд шилжсэн хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийг хэмжихэд олон төрлийн өгөгдөл ашигласан бол Компани хөрөнгө, өр төлбөрийг бүх хэмжсэн үнэ цэнд нөлөөлөхүйц бодит үнэ цэний шатлалын дундах өгөгдлийн хамгийн бага түвшинд ангилах ба түвшин хоорондын шилжилтийг тухайн шилжилт хийгдсэн тайлант үеийн эцэст хүлээн зөвшөөрнө.

4 Шинэ буюу шинэчилсэн стандарт болон тайлбар тодруулгуудын хэрэгжилт

Дараах нэмэлт, өөрчлөлт оруулсан стандартууд 2021 оны 1-р сарын 1-нээс хүчин төгөлдөр болсон боловч Компанид мэдэгдэхүйц нөлөө үзүүлээгүй:

Хүүгийн жишиг (IBOR) шинэчлэл – СТОУС 9, НББОУС 39, СТОУС 7, СТОУС 4, СТОУС 16 (2020 оны 8-р сарын 27-нд гаргасан бөгөөд 2021 оны 1-р сарын 1-нээс хойшхи хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж байна)-д оруулсан 2-р шатны нэмэлт өөрчлөлтүүд.

2-р шатны нэмэлт өөрчлөлтүүд нь шинэчлэлийн хэрэгжилтээс үүсэх асуудлууд, тэр дундаа нэг жишиг үзүүлэлтийг өөр хувилбараар солих зэрэг асуудлыг тусгасан.

Нэмэлт өөрчлөлтүүд нь дараах хүрээг хамарна.

IBOR ийн шинэчлэлийн үр дүнд гэрээний мөнгөн гүйлгээг тодорхойлох үндэслэлд гарсан өөрчлөлтийг бүртгэх: Хорогдуулсан өртгийн хэмжилт хамаарах хэрэгслүүдийн хувьд нэмэлт өөрчлөлтүүд нь практикт тохиромжтой байх үүднээс гэрээг тодорхойлох үндэслэлд гарсан өөрчлөлтийг тооцохыг байгууллагуудаас шаарддаг. СТОУС 9-ийн В 5.4.5-д заасан зааврыг ашиглан үр ашигтай хүүгийн түвшинг шинэчлэх замаар IBOR-ын шинэчлэлийн үр дүнд үүссэн мөнгөн гүйлгээ. Үүний үр дүнд шууд ашиг, алдагдлыг хүлээн зөвшөөрөхгүй.

Энэхүү бодит үндэслэл нь зөвхөн ийм өөрчлөлтөд хамаарах бөгөөд зөвхөн IBOR-ийн шинэчлэлийн шууд үр дагавар болох зайлшгүй шаардлагатай хэмжээнд л хамаарах бөгөөд шинэ суурь нь эдийн засгийн хувьд өмнөх суурьтай тэнцэх болно.

СТОУС 0 ийн түр чөлөөлөлтийг хэрэглэж буй давтагчид ч мөн адил практик аргачлалыг хэрэглэх шаардлагатай. Мөн СТОУС 16-д нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд түрээслэгчдээс IBOR-ын шинэчлэлийн үр дүнд ирээдүйн түрээсийн төлбөрийг тодорхойлох үндэслэлийг өөрчилсөн түрээсийн өөрчлөлтийг бүртгэхдээ ижил төстэй практик арга зүйг ашиглахыг шаардаж байна. Хамгаалалтын харилцаан дахь гэрээгээр тодорхойлогдоогүй эрсдэлийн бүрэлдэхүүн хэсгүүдийн 1-р шатны хөнгөлөлтийг дуусгах хугацаа: 2-р үе шатны нэмэлт өөрчлөлтүүд нь аж ахуйн нэгжээс гэрээгээр тодорхойлогдоогүй эрсдэлийн бүрэлдэхүүн хэсэгт 1-р шатны хөнгөлөлтийг ашиглахаа урьдчилан зогсоохыг шаарддаг. Гэрээгээр тодорхойлогдоогүй эрсдэлийн бүрэлдэхүүн хэсэг, эсвэл эрсдэлээс хамгаалах харилцаа тасарсан үед. Эрсдэлийн бүрэлдэхүүн хэсгүүдийн 1-р шатны нэмэлт өөрчлөлтөд дуусах хугацааг заагаагүй.

Хеджийн нягтлан бодох бүртгэлийн тусгай шаардлагуудыг хэрэгжүүлэхээс хамаарах түр зуурын нэмэлт үл хамаарах зүйлүүд: 2-р үе шатны нэмэлт өөрчлөлтүүд нь НББОУС 39 ба СТОУС 9-ын эрсдэлээс хамгаалах нягтлан бодох бүртгэлийн тусгай шаардлагуудыг IBOR-ын шинэчлэлд шууд нөлөөлсөн эрсдэлээс хамгаалах харилцаанд хэрэглэхээс түр зуурын нэмэлт хөнгөлөлтүүдийг олгодог.

5 Тухайн тайлант жилд НББОУС-ын зөвлөлөөс шинээр гаргасан стандартууд

2022 оны 1-р сарын 1-нээс хойш буюу түүнээс хойш эхлэх жилийн тайлант үеүүдэд заавал дагах мөрдөх зарим шинэ стандарт, тайлбарууд гарсан бөгөөд Компани эрт нэвтрүүлээгүй байна.

- Хөрөнгө оруулагч болон түүний хараат компани эсвэл хамтарсан компанийн хооронд хөрөнгө худалдах буюу оруулсан хувь нэмэр – СТОУС 10 ба НББОУС 28-ын нэмэлт өөрчлөлтүүд (2014 оны 9-р сарын 11-ний өдөр гарсан бөгөөд НББОУС-аас тогтоосон өдрөөс буюу түүнээс хойшхи жилийн тайлангуудад хүчин төгөлдөр болно).
- СТОУС 17 "Даатгалын гэрээ" (2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр гарсан бөгөөд 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр болон түүнээс хойш эхэлсэн тайлант үеүүдэд мөрдөгдөж, хүчин төгөлдөр болох хугацааг СТОУС 17-д нэмэлт, өөрчлөлт оруулах замаар 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр болгон өөрчилсөн) СТОУС 17-д нэмэлт, өөрчлөлт оруулах СТОУС 4 (2020 оны 6-р сарын 25-ны өдөр гаргасан бөгөөд 2023 оны 1-р сарын 1-ний өдрөөс хойшхи хугацаанд хүчин төгөлдөр болно).

ХЭСӨГ ТРЕЙД ХК

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн Санхүүгийн Тайлангийн Тодруулга

- Өр төлбөрийг богино болон урт хугацааны гэж ангилах – НББОУС 1-ийн нэмэлт өөрчлөлт (2020 оны 1-р сарын 23-ны өдөр гарсан бөгөөд 2022 оны 1-р сарын 1-ний өдөр болон түүнээс хойшхи хугацаанд хүчин төгөлдөр болно).
- Өр төлбөрийг богино хугацаа болон урт хугацааны бус гэж ангилах, хүчин төгөлдөр болох хугацааг хойшлуулах – НББОУС 1-ийн нэмэлт өөрчлөлт (2020 оны 7-р сарын 15-нд гарсан бөгөөд 2023 оны 1-р сарын 1-нээс хойших хугацаанд хүчин төгөлдөр болно).
- Зориулалтын дагуу ашиглахаас өмнөх орлого, алдагдалтай гэрээнүүд – гэрээг биелүүлэх зардал, Үзэл баримтлалын хүрээний лавлагаа – НББОУС 16, НББОУС 37, СТОУС 3-ын явцуу нэмэлт өөрчлөлт, СТОУС 2018-2020 оны жилийн сайжруулалт – СТОУС 1, СТОУС 9-ийн нэмэлт өөрчлөлт, СТОУС 16 ба НББОУС 41 (2020 оны 5-р сарын 14-ний өдөр гаргасан бөгөөд 2022 оны 1-р сарын 1-ний өдөр буюу түүнээс хойших тайлант тайлангуудад хүчин төгөлдөр болно).
- НББОУС 1 ба СТОУС-ын практик мэдэгдэл 2-д оруулсан нэмэлт өөрчлөлт: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын тодруулга (2021 оны 2-р сарын 12-нд гаргасан бөгөөд 2023 оны 1-р сарын 1-ний өдөр болон түүнээс хойших тайлант тайлангуудад хүчин төгөлдөр болно).
- НББОУС 8-д оруулсан нэмэлт өөрчлөлт: Нягтлан бодох бүртгэлийн тооцооны тодорхойлолт (2021 оны 2-р сарын 12-нд гаргасан бөгөөд 2023 оны 1-р сарын 1-нээс хойших тайлант тайлангуудад хүчин төгөлдөр болно). НББОУС 8-ын нэмэлт өөрчлөлтөөр компаниуд нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлтөөс хэрхэн ялгах ёстойг тодруулсан.
- Нэг удаагийн гүйлгээний үр дүнд бий болсон хөрөнгө, өр төлбөртэй холбоотой хойшлогдсон татвар – НББОУС 12-ын нэмэлт өөрчлөлт (2021 оны 5-р сарын 7-ны өдөр гарсан бөгөөд 2023 оны 1-р сарын 1-ний өдөр болон түүнээс хойшхи хугацаанд хүчин төгөлдөр болно).

Дээр өөрөөр заагаагүй бол шинэ стандарт, тайлбар нь Компанийн санхүүгийн тайланд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэхгүй.

6 Нягтлан бодох бүртгэлийн гөл бодлогуудын товчоо

6.1 Эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгө, урт ба богино хугацаат өр төлбөрийн ангилал

Компани нь санхүүгийн тайландаа хөрөнгийг эргэлтийн ба эргэлтийн бус, өр төлбөрийг урт ба богино хугацаат гэж ангилдаг. Хөрөнгө нь доорх тохиолдолд эргэлтийн байдаг:

- Эргэлтэд оруулахаар тооцоолж буй мөн хэвийн үйл ажиллагааны үед хэрэглэх зорилготой
- Зөвхөн арилжаалах зорилгоор эзэмшиж буй
- Тайлант үеийн дараах 12 сарын дотор эргэлтэд орохоор хүлээгдэж буй эсвэл
- Тайлант үеийн дараах 12 сарын дотор өр төлбөр төлөх болон солилцохыг хязгаарлаагүй бэлэн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Бусад бүх хөрөнгө эргэлтийн бус гэж ангилагддаг. Доорх тохиолдолд өр төлбөр нь богино хугацаатай байна:

- Хэвийн үйл ажиллагааны циклд төлөгдөхөөр хүлээгдэж буй
- Зөвхөн арилжаалах зорилгоор эзэмшиж буй
- Тайлант үеийн дараах 12 сарын дотор төлөгдөхөөр хүлээгдэж буй эсвэл
- Тайлант үеийн дараах 12 сарын дотор өр төлбөр барагдуулах хугацааг хойшлуулах нөхцөлт бус эрх байхгүй

Компани нь бусад бүх өр төлбөрийг урт хугацаат гэж ангилдаг.

6.2 Гадаад валютын хөрвүүлэг

Компанийн санхүүгийн тайланг Компани үйл ажиллагааны мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөгөөр илэрхийлнэ. Гадаад валютын гүйлгээг анх бүртгэхдээ гүйлгээ хийгдсэн өдрийн ханшаар үйл ажиллагааны мөнгөн нэгж рүү хөрвүүлж бүртгэнэ. Гадаад валютаар бүртгэгдсэн мөнгөн хөрөнгө ба өр төлбөрүүдийг санхүүгийн байдлын тайлангийн өдрийн ханшаар дахин хөрвүүлдэг. Мөнгөн зүйлсийн төлөгдсөн эсвэл хөрвүүлснээс үүссэн бүх зөрүүг ашиг, алдагдлын тайланд бүртгэнэ.

Түүхэн өртөг нь гадаад валютаар хэмжигдэх мөнгөн бус зүйлүүдийг анхны гүйлгээний өдрийн ханшаар хөрвүүлнэ. Бодит үнэ цэнэ нь гадаад валютаар хэмжигдэх мөнгөн бус зүйлүүдийг бодит үнэ цэнэ тодорхойлогдсон өдрийн ханшаар хөрвүүлнэ. Бодит үнэ цэнээрээ хэмжигдэх мөнгөн бус зүйлсийг хөрвүүлснээс үүссэн олз, гарзыг тухайн зүйлийн бодит үнэ цэний өөрчлөлтөөс үүссэн олз, гарзыг хүлээн зөвшөөрөхтэй адилаар авч үзнэ.

ХЭСӨГ ТРЕЙД ХК

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
Санхүүгийн Тайлангийн Тодруулга

6.3 Харилцагчтай байгуулсан гэрээний орлого

Харилцагчидтай хийсэн гэрээний орлогыг бараа бүтээгдэхүүн борлуулсан эсвэл үйлчилгээг үзүүлсний үр дүнд компанийн хүлээж авахаар хүлээгдэж буй орлогыг тусгасан дүнгээр хүлээн зөвшөөрнө. Орлогыг хүлээн зөвшөөрөхөөс өмнө дараах тусгай хүлээн зөвшөөрөлтийн шаардлагуудыг хангах ёстой.

6.4 Хүүгийн орлого

Хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргад үндэслэн хүлээн зөвшөөрнө. Үр ашигт хүүгийн арга гэдэг нь хорогдуулсан өртгөөр хэмждэг санхүүгийн бүх хэрэглүүр, хүүгийн орлогыг шаардлагатай үед санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөрийн бүртгэлийн дүнтэй цэвэршүүлсэн богино хугацааны буюу санхүүгийн хэрэглүүрийн таамагласан хугацаанд тооцоолсон, ирээдүйд хүлээж авах буюу төлөх мөнгөн урсгалын бууруулсан хүүгийн түвшинг ашиглах арга юм. Хүүгийн орлогыг ашиг алдагдлын тайлангийн "Бусад орлого" – д бүртгэнэ.

6.5 Гэрээний өр төлбөр

Урьдчилж орсон орлого гэдэг нь Компани харилцагчтай тохиролцон бараа бүтээгдэхүүн борлуулсан эсвэл үйлчилгээ үзүүлснээр нөхөн төлбөр хүлээн авсан бол (хүлээн авах бол) хүлээх хариуцлага юм. Хэрвээ Компани бараа бүтээгдэхүүн борлуулах эсвэл үйлчилгээ үзүүлэхээс өмнө харилцагч төлбөрийг төлбөл, төлбөр хийгдсэн өдөр эсвэл хийгдэх ёстой өдөр (аль эртээр нь) урьдчилж орсон орлогыг хүлээн зөвшөөрнө. Компани гэрээний дагуу үүргээ гүйцэтгэж дуусах үед урьдчилж орсон орлогыг орлого гэж хүлээн зөвшөөрнө.

6.6 Зардал

Зардлууд нь тайлант хугацааны үед өөрийн хөрөнгийг бууруулж (хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг олгохоос бусад бууралт) буй одийн засгийн огоожийн гадагшлах урсгал, хоронгийн бууралт, өр төлбөрийн нэмэгдлээс үүснэ. Зардлуудыг гарсан үед нь ашиг алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө.

6.7 Ажилчдын тэтгэмж

6.7.1 Богино хугацааны тэтгэмж

Цалин хөлс болон түүнтэй холбогдох бусад зардлуудыг Компанийн ажилтнуудаас холбогдох үйлчилгээг үзүүлсэн тухайн жилд нь зардалд тусгана. Ажилтнуудад ээлжийн амралт зэрэг богино хугацааны чөлөөтэй үед нөхөн олговрыг ажилласан жилийг нь харгалзан олгодог бөгөөд өвчтэй байх хугацааны нөхөн олговрыг цаг тухайд нь олгодог.

6.7.2 Заавал төлөх даатгалын шимтгэлүүд

Монгол улсын холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд нь Монгол улсын эрүүл мэнд, нийгмийн даатгалын санд шимтгэл төлнө. Эдгээр шимтгэлийг гарсан хугацаанд нь ашиг, алдагдлын тайланд зардлаар хүлээн зөвшөөрнө.

6.8 Татвар

6.8.1 Тайлант хугацааны орлогын албан татвар

Одоогийн болон өмнөх тайлант хугацааны өнөөгийн албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг татварын байгууллагаас буцаан авахаар хүлээж байгаа эсвэл татварын байгууллагад төлөх дүнгээр хэмжинэ. Энэ дүнг тооцоолоход хэрэглэсэн татварын хувь хэмжээ, татварын хуулиуд нь санхүүгийн байдлын тайлангийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байсан.

Удирдлага НББ-ийг хэрхэн хөтлөхийг холбогдох татварын хууль, журмуудад тодорхой зааж өгөөгүй, нэмэлт тайлбар тодруулга шаардлагатай тийм шинэ нөхцөл байдал үүссэн эсэхийг тодруулахын тулд тодорхой хугацаа тутамд татварын тайлангаа хянаж үздэг ба шаардлагатай бол сан байгуулдаг.

6.8.2 Хойшлогдсон орлогын албан татвар

Хойшлогдсон орлогын албан татварыг тайлагналын өдрийн байдлаарх хөрөнгө, өр төлбөрийн татварын суурь, тэдгээрийн санхүүгийн бүртгэлийн дүн хоёрын хооронд түр зөрүүний дүнгээс тайлан тэнцлийн аргыг хэрэглэн тооцдог.

Хойшлогдсон албан татварын өр төлбөрийг дор дурдсанаас бусад бүх түр зөрүүнд хүлээн зөвшөөрнө. Үүнд:

ХЭСӨГ ТРЕЙД ХК

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн Санхүүгийн Тайлангийн Тодруулга

- Хойшлогдсон албан татварын өр төлбөр нь гүүдвилийг анх хүлээн зөвшөөрөх үед эсвэл бизнесийн нэгдлийн бус хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээнээс үүссэн, уг гүйлгээ нь НББ-ийн ашиг (алдагдал), татвар ногдох ашиг (алдагдал) – ийн аль алинд нөлөө үзүүлэхгүй байгаа үед,
- Түр зөрүү нь охин болон холбоотой компаниудад оруулсан хөрөнгө оруулалт ба хамтарсан компани дахь ашиг сонирхол зэрэгтэй холбоотойгоор үүссэн, түр зөрүүг хэзээ арилгахыг толгой компани, хөрөнгө оруулагч эсвэл хамтрагч тал хянаж байгаа, түр зөрүү нь ойрын хугацаанд арилахгүй байх магадлалтай байгаа үед

Дор дурдсанаас бусад тохиолдолд хойшлогдсон орлогын албан татварын хөрөнгийг татвар ногдох орлогоос хасагдах бүх түр зөрүүнүүд, ирээдүйд шилжүүлэн тооцох, ашиглаагүй татварын бүх хөнгөлөлт ба алдагдлуудад (эдгээр түр зөрүү, хөнгөлөлт, алдагдлуудыг хасаж болох татвар ногдох орлогын ирээдүйд орж ирэх нь тодорхой болсон үед) хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Татвар ногдох орлогоос хасагдах түр зөрүүтэй холбоотой хойшлогдсон албан татварын хөрөнгө нь бизнесийн нэгдлийн бус хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг анх хүлээн зөвшөөрөх үед үүссэн ба гүйлгээ гарах үед, НББ-ийн болоод татварын ашиг (алдагдал) – ийн аль алинд нөлөө үзүүлэхгүй байгаа үед;
- Татвар ногдох орлогоос хасагдах түр зөрүү нь охин болон холбоотой компаниудад оруулсан хөрөнгө оруулалт ба хамтарсан компани дахь ашиг сонирхолтой холбоотойгоор үүссэн бол хойшлогдсон албан татварын хөрөнгийг, түр зөрүү нь ойрын хугацаанд арилах магадлалтай, түр зөрүүг хасаж болох татвар ногдох орлого орж ирэх нь тодорхой болсон үед зөвхөн хүлээн зөвшөөрнө.

Хойшлогдсон татварын хөрөнгийн бүртгэлийн дүнг тайлант хугацаа бүрийн эцэст хянаж үзэх ба хойшлогдсон татварын хөрөнгийг хэсэгчлэн эсвэл бүхлээр нь нөхөн олж авахад хүрэлцэхүйц хэмжээний татвар ногдох орлого цаашид орж ирэх нь тодорхойгүй болсон үед харгалзах хэмжээгээр хоронгийн дүнг бууруулна. Хүлээн зөвшөөрөөгүй хойшлогдсон татварын хөрөнгийг тайлант хугацаа бүрийн эцэст дахин үнэлж үзэх ба хойшлогдсон татварын хөрөнгийг нөхөн олж авахад хүрэлцэхүйц хэмжээний татвар ногдох орлого цаашид орж ирэх нь тодорхой болсон үед харгалзах хэмжээгээр хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө.

Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийн тайлант хугацааны эцсийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй татварын хувь хэмжээнүүд дээр үндэслэн хөрөнгийг борлуулах, өр төлбөрийг барагдуулах тайлант хугацаанд хэрэглэгдэхээр хүлээгдэж буй татварын хэмжээгээр хойшлогдсон татварыг тооцно.

Хэрэв өнөөгийн татварын хөрөнгийг татварын өр төлбөрт суутгуулах хууль ёсны эрхтэй бөгөөд хойшлогдсон татварууд нь нэг татвар төлөгч аж ахуйн нэгж ба нэг татварын байгууллагатай холбоотой байгаа бол хойшлогдсон албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь цэвэршүүлж болно.

6.8.3 Нэмэгдсэн өртгийн албан татвар

Орлого, зардал болон хөрөнгүүд нь доорхоос бусад тохиолдолд Нэмэгдсэн Өртгийн Албан Татвар (НӨАТ) –гүй цэвэр дүнгээр хүлээн зөвшөөрөгддөг:

- Хөрөнгө эсвэл үйлчилгээг худалдан авахад төлсөн НӨАТ-ыг татварын байгууллагаас буцаан авах боломжгүй үед уг НӨАТ-ыг хөрөнгө худалдан авалтын өртгийн нэг хэсгээр эсвэл зардлын нэг хэсгээр (аль тохиромжтойгоор) хүлээн зөвшөөрнө.
- НӨАТ-ын дүн орсон дүнгээр илэрхийлэгдэх авлага ба өглөг.

Татварын байгууллагаас авах эсвэл татварын байгууллагад өгөх өглөгийн цэвэр дүнг санхүүгийн байдлын тайланд авлага эсвэл өглөгийн нэг хэсэг болгон толилуулна.

6.9 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийг анхны өртгөөр нь бүртгэнэ. Үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх шаардлагууд хангагдсан тохиолдолд л тухайн үндсэн хөрөнгийн сольсон хэсгийн өртгийг тухай бүрт нь энэ өртөгт оруулна. Үндсэн хөрөнгийн томоохон хэсгийг үе шаттайгаар солих шаардлагатай болсон үед Компани нь ийм хэсгүүдийг тусдаа ашиглалтын хугацаа, элэгдэлтэй бие даасан хөрөнгөөр хүлээн зөвшөөрнө. Үүнтэй адил, үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх шаардлагууд хангагдсан бол үндсэн хяналт хийх үед түүний өртгийг үндсэн хөрөнгийн бүртгэлийн дүнд оруулна. Бусад бүх засвар үйлчилгээний зардлыг гарсан үед нь ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгана.

Хүлээн зөвшөөрсний дараах үед компьютер, бусад хөрөнгө, тавилга эд хогшил ба машин тоног төхөөрөмж нь хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэний бууралтын алдагдлыг хассан

ХӨСӨГ ТРЕЙД ХК

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн Санхүүгийн Тайлангийн Тодруулга

өртгөөр илэрхийлдэг. Үндсэн хөрөнгийг дараах ашиглалтын хугацааны туршид, шулуун шугамын аргыг ашиглан хорогдуулна:

Хөрөнгийн төрөл	Ашиглалтын хугацаа (жилээр)
Барилга	25 жил
Тоног төхөөрөмж	10 жил
Автомашин	10 жил
Тавилга	10 жил
Компьютер	2 жил
Бусад хөрөнгө	10 жил

Үндсэн хөрөнгийг худалдан борлуулах үед эсвэл түүний ашиглалт, борлуулалтаас ирээдүйд эдийн засгийн үр ашгийн хүлээлт үгүй болсон үед үл хүлээн зөвшөөрнө.

Үндсэн хөрөнгийн борлуулалтын цэвэр орлого (хэрэв байгаа бол), дансны цэвэр үнэ хоёрын зөрүүг орлогын тайланд хүлээн зөвшөөрнө. Үндсэн хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын хугацаа, элэгдлийн арга нь өмнө хийгдсэн тооцоолол ба үндсэн хөрөнгөд агуулагдаж буй ирээдүйн эдийн засгийн үр ашгийн хүлээгдэж буй хэрэглээний хэв загварт нийцэж байгаа гэдгийг баталгаажуулах үүднээс үндсэн хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын хугацаа, элэгдлийн аргыг санхүүгийн жилийн эцэс бүрт хянаж үздэг.

6.10 Санхүүгийн хөрөнгө ба Санхүүгийн өр төлбөр

Санхүүгийн хэрэглүүр нь нэг байгууллагын санхүүгийн хөрөнгийг өсгөж нөгөө байгууллагын санхүүгийн өр төлбөр эсвэл эздийн өмчийг өсгөдөг аливаа гэрээ юм.

6.10.1 Санхүүгийн хөрөнгө

Анхны хүлээн зөвшөөрөлт болон хэмжилт

Санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд эсвэл ашиг алдагдлын тайланд бүртгэдэг ба дараа нь хорогдуулсан өртгөөр нь хэмждэг. Санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө санхүүгийн хөрөнгийн мөнгөн гүйлгээний шинж тэмдгийг харгалзан үзэж мөн Компанийн уг санхүүгийн хөрөнгийг зохицуулах бизнесийн моделийг харгалзан ангилна. Санхүүгийн томоохон хэсгийг агуулаагүй эсвэл практик хэрэглээ хийгээгүй авлагын дансаас бусад санхүүгийн хөрөнгийг анхлан бодит үнэ цэнээр нь хэмждэг.

Ашиг алдагдлын тайланд бодит үнэ цэнээр бүртгэгдээгүй санхүүгийн хөрөнгийг гүйлгээний өртгөөр бүртгэнэ. Санхүүгийн томоохон хэсгийг агуулаагүй эсвэл практик хэрэглээ хийгээгүй авлагын дансыг НББОУС 9-ийн дагуу гүйлгээний дүнгээр нь хэмждэг. "Харилцагчтай хийсэн гэрээний орлого" хэсгийн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг харна уу.

Санхүүгийн хөрөнгийг хорогдуулсан өртөгт ангилж хэмжихийн тулд, эсвэл бусад ашиг алдагдлын тайланд бодит үнэ цэнээр бүртгэхийн тулд санхүүгийн хөрөнгө нь мөнгөн гүйлгээний "үндсэн болон хүүгийн төлбөр (ҮБХТ)" хэсгийн үндсэн дүнгийн үлдэгдлийг ихэсгэх хэрэгтэй. Энэхүү үнэлгээг ҮБХТ тест гэж нэрлэдэг бөгөөд хэрэглүүрийн түвшинд хийдэг. Компанийн санхүүгийн хөрөнгийг зохицуулдаг бизнес модель нь мөнгөн гүйлгээг үүсгэхийн тулд санхүүгийн хөрөнгийг хэрхэн зохицуулдаг талаар дурдсан байдаг. Мөнгөн гүйлгээ нь гэрээт мөнгөн гүйлгээг цуглуулснаас, санхүүгийн хөрөнгийг борлуулснаас, эсвэл аль алианаас нь үүсэх эсэхийг бизнес модель нь тодорхойлдог.

Хуулийн дагуу тодорхой цаг хугацаанд санхүүгийн хөрөнгийг хүргэхийг шаарддаг худалдан авалт эсвэл борлуулалт нь худалдаа хийсэн өдрөөр хүлээн зөвшөөрөгддөг. Жишээлбэл: Компани хөрөнгийг худалдаж авсан эсвэл борлуулсан өдөр.

Дараах үеийн хэмжилт

Дараах үеийн хэмжилтийн зорилгоор санхүүгийн хөрөнгийг дөрөв ангилдаг:

- Хорогдуулсан өртгөөр нь бүртгэх санхүүгийн хөрөнгө (өрийн хэрэглүүр)
- Бодит үнэ цэний өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх, хуримтлагдсан ашиг, алдагдлыг орлого, зардлын тайланд бүртгэх санхүүгийн хөрөнгө (өрийн хэрэглүүр)
- Бодит үнэ цэний өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх, хуримтлагдсан ашиг, алдагдлыг орлого, зардлын тайланд бүртгэхгүй санхүүгийн хөрөнгө (эздийн өмчийн хэрэглүүр)
- Бодит үнэ цэний өөрчлөлт нь ашиг алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө

ХЭСӨГ ТРЕЙД ХК

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн Санхүүгийн Тайлангийн Тодруулга

Хорогдуулсан өртгөөр нь бүртгэх санхүүгийн хөрөнгө (өрийн хэрэглүүр)

Энэ төрөл нь Компанид хамгийн их тохирдог. Дараах хоёр нөхцөл бүрдсэн тохиолдолд Компани санхүүгийн хөрөнгөө хорогдуулсан өртгөөр хэмжинэ:

- Гэрээт мөнгөн гүйлгээг цуглуулах зорилготой бизнесийн моделийн дагуу эзэмшдэг санхүүгийн хөрөнгө.
- Үндсэн төлбөр болон үлдэгдэл үндсэн дүнгийн хүүний төлбөр болох мөнгөн гүйлгээг тодорхой өдрүүдэд бий болгодог санхүүгийн хөрөнгийн гэрээний нөхцөлүүд.

Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн хөрөнгө нь тайлангийн дараа үед үр ашигт хүүгийн аргаар хэмжигдэх ба үнэ цэний бууралтад орно. Хөрөнгө нь үл хүлээн зөвшөөрөгдөх, өөрчлөгдөх эсвэл үнэ цэний бууралтад орсон тохиолдолд олз гарзыг ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн хөрөнгө нь худалдааны болон бусад авлага, мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө зэргээс бүрдэнэ.

Үл хүлээн зөвшөөрөлт

Дараах тохиолдолд санхүүгийн хөрөнгийг (хэрэглэх боломжтой бол, санхүүгийн хөрөнгийн хэсгийг эсвэл хоорондоо төсөөтэй нэг бүлэг санхүүгийн хөрөнгийн хэсгийг) үл хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Тухайн хөрөнгөөс мөнгөн урсгал хүлээн авах эрх нь дууссан;
- Компани нь тухайн хөрөнгөөс мөнгөн урсгал хүлээн авах эрхээ шилжүүлсэн эсвэл "дамжуулан өнгөрөөх" хэлцлийн дагуу хүлээн авсан мөнгөө нийт дүнгээр нь удаан хугацаагаар саатуулалгүйгээр гуравдагч талд төлөх үүрэг хүлээсэн; мөн: а) компани хөрөнгийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлсэн; эсвэл б) компани тухайн хөрөнгөтэй холбоотой эрсдэл ба өгөөжийг шилжүүлээгүй боловч хөрөнгийн хяналтыг шилжүүлсэн.

Компани хөрөнгөөс мөнгө хүлээн авах эрхээ шилжүүлсэн эсвэл "дамжуулан өнгөрөөх" хэлцэл хийсэн боловч хөрөнгөтэй холбоотой ихэнх эрсдэл, өгөөж болон хяналтыг шилжүүлээгүй тохиолдолд хөрөнгийг Компанийн уг хөрөнгөнд үргэлжлүүлэн оролцоор байх хэмжээгээр нь хүлээн зөвшөөрнө. Энэ тохиолдолд Компани холбогдох өр төлбөрийг мөн хүлээн зөвшөөрнө. Шилжүүлсэн хөрөнгө ба холбогдох өр төлбөрийг Компанийн хадгалж үлдсэн эрх, үүргийг тусган харуулсан сууриар хэмжинэ. Энэхүү үргэлжилсэн оролцоо нь шилжүүлсэн хөрөнгийн баталгаа хэлбэртэй байвал оролцоог тус хөрөнгийн анхны бүртгэлийн дүн ба Компанийн төлөх шаардлагатай болох хамгийн их дүнгийн аль багаар хэмжинэ.

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэний бууралт

Компани нь бодит үнэ цэний бууралт нь ашиг алдагдлын тайланд бүртгэгдэхгүй бүх өрийн хэрэглүүрийн хувьд "зээлийн үнэ цэний хүлээгдэж буй алдагдал (ЗҮЦХА)" – ыг тооцож сан байгуулна. ЗҮЦХА нь гэрээний дагуу хийгдэх мөнгөн гүйлгээ ба Компанийн хүлээж буй бүх мөнгөн урсгалуудыг анхны үр ашигт хүүг ашиглан тооцоолж хассан дүнгийн зөрүү дээр суурилдаг. Компанийн хүлээгдэж буй мөнгөн урсгалууд гэдэг нь гэрээний барьцаа хөрөнгө эсвэл гэрээний нөхцөлтэй салшгүй холбоотой зээлийн бусад сайжруулалтын мөнгөн урсгалуудыг хэлнэ.

ЗҮЦХА-г хоёр үе шатаар хүлээн зөвшөөрнө. Хэрэв анх хүлээн зөвшөөрснөөс хойш зээлийн эрсдэлд мэдэгдэхүйц өсөлт гараагүй бол ЗҮЦХА-г дараагийн 12 сарын болзошгүй алдагдлын магадлалд үндэслэнэ. Анх хүлээн зөвшөөрснөөс хойш зээлийн эрсдэл мэдэгдэхүйц ихэссэн тохиолдолд төлбөрийн хугацааг үл харгалзан үлдсэн бүх хугацааны туршид хүлээгдэж буй ЗҮЦХА-г байгуулна.

Компанийн зүгээс гэрээний төлбөр хугацаа 90 хоногоос хэтэрсэн тохиолдолд авлагын эрсдэл мэдэгдэхүйц өссөн гэж үздэг.

Компанийн гэрээний төлбөр 365 хоногоос дээш хугацаагаар хэтэрсэн тохиолдолд тухайн санхүүгийн хөрөнгийг алдагдал гэж үзнэ. Гэвч зарим тохиолдолд Компанийн хугацаанаас үл хамааран гэрээний үлдэгдэл төлбөрийг бүрэн хэмжээгээр авах магадлал багатай байна гэж үзвэл тухайн санхүүгийн хөрөнгийг алдагдал гэж тооцож болно. Гэрээнд заасан мөнгөн урсгалыг олох хүлээлт байхгүй гэж үзсэн тохиолдолд санхүүгийн хөрөнгийг дансанд хасна.

6.10.2 Санхүүгийн өр төлбөр

Анхны хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

ХӨСӨГ ТРЕЙД ХК

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн Санхүүгийн Тайлангийн Тодруулга

Санхүүгийн өр төлбөрийг аль зохистой ангилалд нь бодит үнэ цэний өөрчлөлт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэх, зээл ба зээллэг, эсвэл үр нөлөөтэй хейджингийн хэрэглүүрээр анх хүлээн зөвшөөрнө. Бүх санхүүгийн өр төлбөрүүдийг анх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөх ба зээл, зээллэг болон өр төлбөрийн хувьд шууд хамааралтай гүйлгээний зардлыг хассаны дараах дүнгээр хүлээн зөвшөөрнө. Компанийн санхүүгийн өр төлбөрт бусад өр төлбөр болон холбоотой талын өр төлбөр орно. Бүх санхүүгийн өр төлбөрийг зээл ба зээллэг гэж ангилдаг.

Үл хүлээн зөвшөөрөлт

Санхүүгийн өр төлбөрийг төлөхөөс чөлөөлөгдсөн, өр төлбөр цуцлагдсан эсвэл хугацаа нь дууссан бол үл хүлээн зөвшөөрдөг. Хэрэв одоо байгаа санхүүгийн өр төлбөрийн зээлдүүлэгч нь хэвээрээ боловч ялгаатай нөхцөлтэй зээлийн гэрээгээр сольсон эсвэл одоо байгаа зээлийн нөхцөл эрс өөрчлөгдсөн бол эдгээр өөрчлөлт шинэчлэлтийг анхны санхүүгийн өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт ба шинэ өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт гэж үзэх ба бүртгэлийн дүнгийн зөрүүг орлого, зардлын дансанд хүлээн зөвшөөрнө

6.10.3 Санхүүгийн хэрэглүүрүүдийг цэвэршүүлэх

Хэрэв байгууллага хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг цэвэршүүлэх хуулиар олгогдсон эрхтэй, тооцоог цэвэр дүнгээр нь барагдуулах, эсвэл хөрөнгийг борлуулж өр төлбөрийг нь барагдуулах ажлыг нэгэн зэрэг хийхээр зэхэж байгаа л бол санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрүүдийг хооронд нь цэвэршүүлэн, цэвэр дүнгээр тайлан тэнцэлд толилуулах эрхтэй.

6.10.4 Санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ

Санхүүгийн хэрэглүүрийн богино хугацааны төлбөртэй холбоотойгоор уг хэрэглүүрийн бодит үнэ цэнэ нь дансны үнэтэй ойролцоо байна гэж удирдлага тооцсон.

6.10.5 Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгөд бэлэн мөнгө болон банкин дахь дансанд байршуулсан мөнгө орно. Мөнгөн гүйлгээний тайлангийн зорилгоор, банкин дахь бэлэн мөнгө нь дээр тодорхойлсноор банкин дахь харилцах болон богино хугацаат хадгаламжийн дүнгээс бүрдэнэ.

6.10.6 Түрээс

Тухайн гэрээ нь түрээсийн гэрээ эсвэл түрээс агуулж байгаа эсэхийг тодорхойлохдоо гэрээний агуулга дээр үндэслэх ба гэрээг гүйцэтгэхэд тусгай хөрөнгийг ашиглах шаардлагатай эсэх ба гэрээ нь хөрөнгийг ашиглах эрхийг шилжүүлж байгаа эсэх зэргийг үнэлж үзэх шаардлагатай.

6.10.7 Компани түрээслэгч үед

Компани богино хугацаат түрээс болон бага үнэ цэнэ бүхий хөрөнгийн түрээсээс бусад бүх түрээсийн хүлээн зөвшөөрөлт болон хэмжилтийн нэг аргыг хэрэглэнэ. Компани түрээсийн төлбөрийг төлөөлж "түрээсийн өр төлбөр"-ийг хүлээн зөвшөөрч, тодорхойлсон хөрөнгийг түрээслэн ашиглах эрхийг төлөөлж "ашиглах эрхтэй хөрөнгө"-ийг хүлээн зөвшөөрнө.

6.10.8 Ашиглах эрхтэй хөрөнгө

Компани ашиглах эрхтэй хөрөнгийг түрээсийн эхлэх өдөр (хөрөнгийг ашиглаж эхлэх боломжтой болсон өдөр) эхлэн хүлээн зөвшөөрнө. Ашиглах эрхтэй хөрөнгийг хуримтлагдсан элэгдэл, аливаа үнэ цэний бууралтын алдагдлыг хасаж өртгөөр нь хэмжих бөгөөд түрээсийн өр төлбөрийг дахин үнэлэхэд тохируулна. Ашиглах эрхтэй хөрөнгийн өртөг нь хүлээн зөвшөөрөгдсөн түрээсийн өр төлбөр, анхны шууд өртөг, түрээсийн урамшууллыг хүлээн авахаас өмнө буюу өмнөх өдрөөс эхлэн хийсэн түрээсийн төлбөрүүд багтана. Ашиглах эрхтэй хөрөнгө нь оффисын түрээсийн хугацааны туршид буюу 3 жилийн хугацаанд шулуун шугамын аргаар элэгдэх юм.

6.10.9 Түрээсийн өр төлбөр

Компани түрээсийн хугацааны туршид төлөх төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнээр хэмжсэн түрээсийн өр төлбөрийг түрээс эхлэх өдөр хүлээн зөвшөөрнө. Түрээсийн төлбөр гэдэгт аливаа урамшуулал хөнгөлөлтийг хассан түрээсийн тогтмол төлбөрөөс гадна хувь хэмжээнээс хамаарах хувьсах шинжтэй төлбөр, үлдэгдэл үнийн баталгааны дагуу төлөхөөр хүлээгдэж буй төлбөрүүдийг хамруулан авч үзнэ. Хувьсах шинжтэй түрээсийн төлбөр нь ямар нэг индекс, хувь хэмжээнээс хамааралгүй (бараа материал үйлдвэрлэхэд зориулж гаргаагүй бол) бол түүнийг тайлант хугацааны зардлаар хүлээн зөвшөөрнө.

6.10.10 Өөрийн хөрөнгө

ХӨСӨГ ТРЕЙД ХК

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
Санхүүгийн Тайлангийн Тодруулга

Энгийн хувьцааг өөрийн хөрөнгөнд ангилна. Энгийн хувьцааны ногдол ашгийг зарласан үедээ өөрийн хөрөнгөнд хүлээн зөвшөөрдөг. Өөрийн хөрөнгийн гүйлгээний өртөгт зөвхөн өөрийн хөрөнгийн гүйлгээнд шууд холбоотой гаднын нэмэгдүүлсэн өртгөөс бусад өртгийг оруулахгүй.

6.10.11 Болзошгүй өр төлбөр ба хөрөнгө

Болзошгүй өр төлбөрүүд нь санхүүгийн тайлангуудад хүлээн зөвшөөрөгдөөгүй бөгөөд санхүүгийн тайлангийн тодруулгад толилуулдаг. Харин ирээдүйн эдийн засгийн үр өгөөжийг компани хүртэх магадлалтай болсон үед санхүүгийн тайлангийн тодруулгад толилуулна.

6.10.12 Холбоотой талууд

Холбоотой талууд гэдэгт Компанитай дараах байдлаар холбогдсон аж ахуй нэгж болон хувь хүн орно. Үүнд:

- a) Компанитай дараах байдлаар холбогдсон хувь хүн эсвэл тухайн хувь хүний ойрын төрөл садан:
 - i) Компанид дангаараа эсвэл хамтран хяналт тогтоосон;
 - ii) Компанид томоохон нөлөөлөлтэй эсвэл
 - iii) Компанийн эсвэл Компанийн толгой компанийн гол удирдах албан тушаалтнуудын нэг.
- b) Дараах нөхцөлүүдийн аль нэг нь биелсэн тохиолдолд аж ахуй нэгж нь Компанид хамааралтай болно. Үүнд:
 - i) Аж ахуй нэгж болон Компани нь нэг ижил Группийн гишүүд байх (толгой компани, охин компани болон нөгөө охин компани тус бүр нь бусадтайгаа холбоотой).
 - ii) Нэг аж ахуй нэгж нь нөгөө аж ахуй нэгжийн хараат компани эсвэл хамтын хэлэлцээрт компани (эсвэл нөгөө аж ахуй нэгж нь гишүүн болох Компанийн хараат компани эсвэл хамтарсан хэлэлцээрт компани).
 - iii) Аль аль аж ахуй нэгж нь нэг ижил гуравдагч этгээдийн хамтарсан хэлэлцээрт компаниуд.
 - iv) Нэг аж ахуй нэгж нь гуравдагч аж ахуй нэгжийн хамтарсан хэлэлцээрт компани бөгөөд нөгөө этгээд нь гуравдагч аж ахуй нэгжийн хараат компани.
 - v) Аж ахуй нэгж нь Компанийн эсвэл Компанитай холбоотой аж ахуй нэгжийн ажиллагсдыг урамшуулах зорилгоор ажил эрхлэлтийн дараах тэтгэмж олгодог. Хэрвээ Компани нь уг хөтөлбөрийг хэрэгжүүлдэг бол дэмжлэг хүртэж буй ажиллагсад нь мөн Компанитай холбоотой тал болно.
 - vi) Аж ахуй нэгжийг (а)-д тодорхойлсон хувь хүн дангаараа эсвэл хамтран хяналт тогтоодог.
 - vii) (а) (i)-д тодорхойлсон хувь хүн нь аж ахуй нэгжид томоохон нөлөөлөлтэй эсвэл уг аж ахуй нэгжийн (эсвэл аж ахуй нэгжийн толгой компанийн) гол удирдах албан тушаалтнуудын нэг.
 - viii) Аж ахуй нэгж нь эсвэл Компанийн аль нэг гишүүн нь Компани эсвэл Компанийн толгой компанид гол удирдах албан тушаалтай.

ХӨСӨГ ТРЕЙД ХК

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн Санхүүгийн Тайлангийн Тодруулга

7 Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө данс нь дараах үлдэгдэлтэй байна.

(Төгрөгөөр)	2022.12.31	2023.12.31
Касс дахь бэлэн мөнгө	0.00	0.00
Харилцах дахь мөнгө	294,911,421.32	6,630,896.92
Дүн	294,911,421.32	6,630,896.92

7.1 Касс дахь бэлэн мөнгө

(Төгрөгөөр)	2022.12.31	2023.12.31
Төгрөг	-	-
Дүн	-	-

7.2 Банкин дах харилцах данс

(валютаар)	2022.12.31	2023.12.31
Төгрөг MNT	294,911,421.32	6,630,896.92
Ам доллар USD	-	-
Дүн	294,911,421.32	6,630,896.92

8 Дансны авлага болон бусад авлага

Дансны авлагын хураангуй дараах байдалтай байна.

(Төгрөгөөр)	2022.12.31	2023.12.31
Дансны авлага	19,600,000.00	45,853,295.19
Найдваргүй авлагын эрсдэлийн сан	-	-
Дүн	19,600,000.00	45,853,295.19

Компани нь 2023 онд СТОУС 9 буюу санхүүгийн хөрөнгийн бүртгэх тайлагнах стандартыг хэрэгжүүлсэн. Найдваргүй авлагын эрсдэлийн сан байгуулаагүй.

Борлуулалтын авлагын насжилтыг хоногоор дараах байдлаар харуулав.

(Төгрөгөөр)	0-90 хоног	90-180 хоног	360 дээш хоног	Нийт
СКАЙ ЗОН ХХК	19,075,253.46	-	-	19,075,253.46
ПИТИЭС ХХК	5,087,901.70	-	-	5,087,901.70
МЭЙЖИК ТЕК	3,500,000.00	-	-	3,500,000.00
МОНГОЛИА ХХК	4,390,140.03	-	-	4,390,140.03
МЭЙЖИК ТЕК	1,000,000.00	-	-	1,000,000.00
МОНГОЛИА ХХК	7,425,678.00	-	-	7,425,678.00
СХД-н татварын алба	-	-	-	-
Нийслэлийн татварын газар	-	366,204,878.00	-	366,204,878.00
Чимидрагчаа	-	-	1,000,000.00	1,000,000.00
Брайтфлэйм ХХК	-	-	5,800,000.00	5,800,000.00
Уранчимэг	-	-	6,000,000.00	6,000,000.00
Дүн	40,478,973.19	366,204,878.00	12,800,000.00	419,483,851.19

Бусад авлагын хураангуй дараах байдалтай байна.

(Төгрөгөөр)	2022.12.31	2023.12.31
НДШ-ийн авлага	-	-
Ажилчдаас авах авлага	-	-
Дүн	-	-

ХӨСӨГ ТРЕЙД ХК

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
Санхүүгийн Тайлангийн Тодруулга

9 Бараа материал

Бараа материал дансны хураангуй дараах байдалтай байна. Компани нь тайлант үеийн эцэст бараа материалын тооллогыг хийж өртөг, цэвэр боломжит үнэ цэнийг авч үзэн өртгөөр нь илэрхийлсэн.

(Төгрөгөөр)	2022.12.31	2023.12.31
Түүхий эд материал	-	-
Бараа	2,418,036.37	1,207,818.18
Хангамжийн материал	-	-
Дүн	<u>2,418,036.37</u>	<u>1,207,818.18</u>

10 Урьдчилж төлсөн зардал тооцоо

(Төгрөгөөр)	2022.12.31	2023.12.31
НӨАТ-ын тооцоо	-	-
Урьдчилж төлсөн тооцоо	-	373,630,556.00
Дүн	-	<u>373,630,556.00</u>

11 Биет бус хөрөнгө

Биет бус хөрөнгийн өөрчлөлт, хөдөлгөөн дараах байдалтай байна. Компани биет бус хөрөнгийн хорогдлыг өмнөх жилийн үлдэх өртгөөс шууд хасч тайлант оны зардлаар хүлээн зөвшөөрдөг.

(Төгрөгөөр)• Тусгай зөвшөөрөл Тусгай зөвшөөрөл	Компьютер программ хангамж	Газар эзэмших эрх	Нийт дүн
2022.12.31-ний үлдэгдэл	<u>543,000.00</u>	<u>403,362,433.49</u>	<u>403,905,433.49</u>
Нэмэгдсэн	-	-	-
Тайлант оны хорогдуулалт	99,931.55	-	99,931.55
2023.12.31-ний үлдэгдэл	<u>443,068.45</u>	<u>403,362,433.49</u>	<u>403,805,501.94</u>

ХӨСӨГ ТРЕЙД ХХ

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн Санхүүгийн Тайлангийн Тодруулга

12 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн өөрчлөлт, хөдөлгөөн дараах байдалтай байна. Компани нь үндсэн хөрөнгөө дахин үнэлгээний загвар ашиглан бүртгэсэн, хөрөнгийн дүн, элэгдүүлэх хугацаа, арга нь өмнө хийгдсэн тооцоолол ба үндсэн хөрөнгөнд зугаагдаж буй ирээдүйн эдийн засгийн өгөөжийн хүлээгдэж буй хэрэглээний хэв загварт нийцэж байгаа гэдгийг баталгаажуулах зорилгоор хөрөнгийн үлдэх эстөг, ашиглалтын хугацаа, элэгдлийн аргыг санхүүгийн жилийн эцэс бүрд хянаж үздэг.

(Төгрөгөөр)	Барилга байгууламж	Машин, тоног төхөөрөмж	Тээврийн хэрэгсэл	Тавилга, эд хогшил	Компьютер дагалдах хэрэгсэл	Бусад хөрөнгө	Нийт дүн
ӨРТӨГ							
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	561,476,510.52	4,234,993.14	4,452,602.76	2,015,791.14	1,545,339.81	-	573,765,237.37
Өөрөө үйлдвэрлэсэн Хувилдаж авсан	-	-	-	-	-	-	-
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	561,476,510.52	4,234,993.14	4,452,602.76	2,015,791.14	1,545,339.81	-	573,765,237.37
ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ							
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	-	-	-	-	-	-
Байгуулсан элэгдэл	121,804,875.16	4,234,993.14	559,671.43	366,925.60	1,545,339.81	-	128,551,805.14
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	121,804,875.16	4,234,993.14	559,671.43	366,925.60	1,545,339.81	-	128,551,805.14
ДАНСНЫ ЦЭВЭР ДҮН							
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	561,476,510.52	4,234,993.14	4,452,602.76	2,015,791.14	1,545,339.81	-	573,765,237.37
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	439,671,635.36	-	3,892,931.33	1,648,865.54	-	-	445,213,432.23

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр компани өөрийн бараа материал, тоног төхөөрөмж мөн барилга, байгууламж зэргийг барьцаалсан мэдээлэл байхгүй байна.

ХЭСӨГ ТРЕЙД ХК

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн Санхүүгийн Тайлангийн Тодруулга

13 Дансны болон бусад өглөг

13.1 Дансны өглөг

Дансны өглөг дансны хураангуй дараах байдалтай байна.

(Төгрөгөөр)	2022.12.31	2023.12.31
Дансны өглөг	5,814,034.86	139,926,563.59
Дүн	5,814,034.86	139,926,563.59

13.2 Бусад өглөг

Бусад өглөг дансны хураангуй дараах байдалтай байна.

(Төгрөгөөр)	2022.12.31	2023.12.31
Цалингийн өглөг	271,000.00	-
Дүн	271,000.00	-

14 Банкны зээл

Банкны зээлийн үлдэгдэл дараах байдалтай байна.

(Төгрөгөөр)	2022.12.31	2023.12.31
Банкны зээл	-	-
Дүн	-	-

Банкнаас зээл аваагүй байна.

15 Урьдчилж орсон орлого

Компани нь бүтээгдэхүүн хүргэлттэй уялдуулан тайлант хугацааны орлогоор хүлээн зөвшөөрдөг. Жил бүр дараагийн тайлант хугацаанд ногдох орлогыг богино хугацаат урьдчилж орсон орлого ороогүй байна.

(Төгрөгөөр)	2022.12.31	2023.12.31
Урьдчилж орсон орлого	-	-
Дүн	-	-

16 Нөөц өр төлбөр

Нөөц өр төлбөр байгуулаагүй, үлдэгдэлгүй байна.

17 Татварын өглөг

Татварын өглөгийн хураангуй дараах байдалтай байна.

(Төгрөгөөр)	2022.12.31	2023.12.31
Нэмэгдсэн өртгийн албан татварын өглөг	269,570.02	1,873,797.70
Хувь хүний орлогын албан татварын өглөг	163,680.00	-
Дүн	433,250.02	1,873,797.70

18 Орлогын татварын зардал

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилд орлогын албан татвар дараах байдалтай байна:

(Төгрөгөөр)	2022.12.31	2023.12.31
-------------	------------	------------

ХӨСӨГ ТРЕЙД ХК

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн Санхүүгийн Тайлангийн Тодруулга

Татвар төлөхийн өмнөх ашиг	(124,159,700.00)	(125,011,487.88)
Татварын байнгын зөрүү:		
Тусгай хувь хэмжээтэй орлого	-	4,307,931.17
Хасагдахгүй зардал	26,615,900.00	17,680.70
Байнгын зөрүүгээр зохицуулагдсан татвар ногдуулах орлого:	(150,775,600.00)	(129,337,099.75)
Татварын түр зөрүү:	-	-
Ханшийн зөрүүний бодит бус олз	-	-
Өмнөх үеийн бодит бус олзноос бодит болж хэрэгжсэн	-	-
Түр зөрүүгээр зохицуулагдсан татвар ногдуулах орлого:	-	-
Нийтлэг хувь хэмжээгээр ногдуулсан татвар	-	-
Тусгай хувь хэмжээгээр бусдад суутгуулсан татвар	-	430,793.12
Тайлант жилийн нийт татварын зардал	-	430,793.12

2023 оноос хэрэгжиж байгаа ААНОАТ-ын шинэ хуулийн дагуу тайлант үеийн Орлогын албан татварыг 10 хувиар ногдуулсан.

Монгол Улсын татварын эрх бүхий байгууллага нь өөрийн хуулийн талаарх тайлбар болон байр сууриндаа илүү хатуу хандаж болох бөгөөд өмнө нь татварын аливаа асуудал үүсч байгаагүй ажил гүйлгээ, үйл ажиллагаанд татварын аливаа асуудал үүсэхийг үгүйсгэхгүй юм. Үүний үр дүнд, нөлөөлөхүйц хэмжээний нэмэлт татвар, торгууль болон хүүг ногдуулж болох юм. Татварын шалгалт хийх хугацааны хувьд шалгалт хийх тайлант жилдөө өмнөх 4 жилийн хугацааг хамарч болно. Сарим тухайлсан тохиолдолд түүнээс ч урт хугацааг хамарч болно.

Үнэ шилжилттэй холбоотой Монгол Улсын хуулийн заалтууд нь 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн ба тодорхой онцлог шинж чанарыг агуулсан ч Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллагаас боловсруулсан олон улсын үнэ шилжилттэй холбоотой зарчимд ерөнхийдөө суурилсан. Үнэ шилжилттэй холбоотой хуулийн зохицуулалт нь тухайн байгууллагын хяналтад байгаа ажил гүйлгээнүүд (холбоотой талуудын хооронд хийгдсэн ажил гүйлгээ, мөн зарим холбоогүй талуудын хооронд хийгдсэн ажил гүйлгээ) хэрэв сунгасан гарын зарчмаар хэрэгжээгүй бол татварын аливаа эрсдэл үүсэх зохицуулалттай. Удирдлага нь одоогийн үнэ шилжилттэй холбоотой хууль тогтоомжийг дагаж мөрдөх төлөвлөгөө, журмыг хэрэгжүүлж байгаа.

19 Эздийн өмч

Хувьцаат капитал нь тайлант хугацааны эцэст дараах үлдэгдэлтэй байна.

Хувьцаа эзэмшигчид	Хувь эзэмшил	Эзэмшиж буй хувьцааны тоо	2022.12.31 (төгрөг)	2023.12.31 (Төгрөг)
О.Дамжин	0.8%	2,338	233,800.00	233,800.00
С.Жавзан-Орлом	17.6%	51,974	5,197,400.00	5,197,400.00
Эй Ди ЭмЭм Ди ХХК	32.6%	96,357	9,635,700.00	9,635,700.00
Д.Бадам	29.8%	88,118	8,811,800.00	8,811,800.00
Г.Маргад	18.2%	53,916	5,391,600.00	5,391,600.00
Бусад	1.0%	3,090	309,000.00	309,000.00
НИЙТ ДҮН	100.0%	295,793	29,579,300.00	29,579,300.00

Компанийн дүрмийн сан нь тайлант хугацааны эцэст нэг бүр нь 100 тогрогийн нэрлэсэн үнэтэй 295,793 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэж байна.

Компанийн хуримтлагдсан ашгийн данс нь дараах байдалтай байна.

2022.12.31-ний үлдэгдэл	(38,315,672.12)
Хуваарилсан ногдол ашиг	-
Тайлант жилийн цэвэр ашгаар нэмэгдсэн	(125,442,281.01)
2023.12.31-ний үлдэгдэл	(163,757,953.13)
Ногдол ашиг зарлаагүй байна.	

ХЭСӨГ ТРЕЙД ХК

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн Санхүүгийн Тайлангийн Тодруулга

20 Урт хугацаат өр төлбөр

(Төгрөгөөр)	2022.12.31	2023.12.31
Урт хугацаат зээл	-	-
Бусад урт хугацаат өр төлбөр	386,578,229.49	359,690,010.49
Дүн	<u>386,578,229.49</u>	<u>359,690,010.49</u>

21 Орлого

Борлуулалтын орлого дараах байдалтай байна:

(Төгрөгөөр)	2022.12.31	2023.12.31
Ажил үйлчилгээ борлуулсны орлого	-	62,272,727.28
Дүн	<u>-</u>	<u>62,272,727.28</u>

22 Борлуулалтын өртөг

Борлуулалтын өртөг дараах байдалтай байна:

(Төгрөгөөр)	2022.12.31	2023.12.31
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	-	-
Дүн	<u>-</u>	<u>-</u>

23 Үйл ажиллагааны зардал

Үйл ажиллагааны зардал дараах байдалтай байна:

Үзүүдэлт	2022.12.31	2023.12.31
Борлуулалт маркетингийн зардал	-	-
Ерөнхий удирдлагын зардал	324,295,500.00	249,604,164.62
Дүн	<u>324,295,500.00</u>	<u>249,604,164.62</u>

24 Бусад орлого, зардал

24.1 Бусад орлого

Бусад орлогын дэлгэрэнгүй дараах байдалтай байна:

(Төгрөгөөр)	2022.12.31	2023.12.31
Бусад орлого	47,494,800.00	58,029,698.99
Дүн	<u>47,494,800.00</u>	<u>58,029,698.99</u>

24.2 Бусад зардал

Бусад зардлын дэлгэрэнгүй дараах байдалтай байна:

(Төгрөгөөр)	2022.12.31	2023.12.31
Хөрөнгө акталж устгасны зардал	26,615,900.00	17,680.70
Дүн	<u>26,615,900.00</u>	<u>17,680.70</u>

25 Бусад ашиг, алдагдал

Бусад ашиг, алдагдал байхгүй байна.

26 Санхүүгийн орлого, зардал

Санхүүгийн орлого, зарлага байхгүй байна.

ХӨСӨГ ТРЕЙД ХК

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн Санхүүгийн Тайлангийн Тодруулга

27 Эрсдэлийн удирдлагын тогтолцоо

Компанийн удирдлага нь Компанийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог бий болгох, түүнийг хянах ерөнхий үүрэг хариуцлагыг хүлээж байдаг. Түүнчлэн Компанийн удирдлага нь эрсдэлийн удирдлагын бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих зэрэг үйл ажиллагаа өдөр тутам хийгдэж байгаа эсэхэд үүрэг хариуцлага хүлээдэг. Удирдлага нь хувьцаа эзэмшигчдэд үйл ажиллагааныхаа талаар тайлагнадаг.

Компанийн эрсдэлийн удирдлагын бодлого нь Компанид тулгарч буй эрсдэлүүдийг тодорхойлох, шинжлэх, тохиромжтой эрсдэлийн хязгаар, хяналтыг бий болгох, эрсдэлийг хянах, хязгаарыг мөрдөхөд чиглэгдсэн байдаг. Эрсдэлийн удирдлагын бодлого болон систем нь зах зээлийн нөхцөл байдал болон Компанийн үйл ажиллагаанд гарч байгаа аливаа өөрчлөлтүүдийг тусгахын тулд байнгын хяналт сайжруулалтын дор байдаг. Компани нь өөрийн сургалт, удирдлагын стандарт болон дүрэм журмаараа дамжуулан ажилтнууд өөрсдийн үүрэг хариуцлагыг бүрэн ухамсарласан байх зохион байгуулалт бүхий, бүтээлч хяналт бүхий орчныг бий болгохоор зорин ажилладаг.

Хөсөг Трейд ХК нь зээлийн болон бусад эрсдэлийн удирдлагаар хангах үүрэгтэй бөгөөд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн зөвшөөрөл шаардлагатай буюу тодорхой түвшнээс дээших хэмжээний томоохон хэлцлүүдийг хянан үзэх байдлаар ажилладаг. Мөн түүнчлэн худалдан авалт болон борлуулалтын урт хугацаатай гэрээ, хэлцэл болон капитал хөрөнгө оруулалт, зээл зэрэг харьцангуй төвөгтэй урт хугацааны шинжтэй хэлцлүүдэд хэлэлцээр хийх болон зохион байгуулалтыг Хувьцаа эзэмшигчийн хурлаар хэлэлцэн шийдвэр гаргадаг.

27.1 Төлбөрийн чадварын эрсдэл

Төлбөрийн чадварын эрсдэл нь санхүүгийн өр төлбөртэй хамаарал бүхий үүрэг хариуцлагаа биелүүлэхэд компанид тулгарч болох аливаа хүндрэлүүд юм. Компанийн төлбөрийн чадвараа удирдах арга хандлага нь өр төлбөрийг хугацаанд нь барагдуулах хангалттай төлбөрийн чадвартай байх, үл хүлээн зөвшөөрөгдөх аливаа алдагдлыг хүлээхгүй байх.

Дараах хүснэгтээрх мэдээлэл нь компанийн санхүүгийн өр төлбөрийг төлөхөд бэлэн байдал, түүнийг төлөх нөөцийн боломжийг харуулна.

(Төгрөгөөр)	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	294,911,421.32	6,630,896.92
Дансны авлага болон бусад авлага	19,600,000.00	45,853,295.19
Дүн	314,511,421.32	52,484,192.11
Санхүүгийн өр төлбөр	-	-
Богино хугацаат өр төлбөр	5,814,034.86	139,926,563.59
Татварын өглөг	433,250.02	1,873,797.70
Урт хугацаат өр төлбөр	386,578,229.49	359,690,010.49
Дүн	392,825,514.37	501,490,371.78

27.2 Валютын ханшийн эрсдэл

Компани өөрийн үйл ажиллагааны валют болох төгрөгөөс бусад валютаар илэрхийлэгдсэн борлуулалт, худалдан авалт, зээлд гадаад валютын ханшийн эрсдэлийг хүлээдэг. Эдгээр ажил гүйлгээний илэрхийлэгдсэн үндсэн валют нь Америкийн доллар юм. Компани валютын ханшийн эрсдэлээс зайлсхийхийн тулд гадаад валютын хэлбэлзлийг тогтмол хянаж, ирээдүйн гадаад валютын мөнгөн урсгалаа удирддаг.

Тайлант жилийн эцэс дэх Монголбанкны хаалтын ханшийг дор үзүүлэв.

	2022.12.31 (төгрөг. мөнгөөр)	2023.12.31 (төгрөг. мөнгөөр)	Хэлбэлзэл +/-
Мөнгөн тэмдэгт			
Ам.Доллар	3,444.60	3,410.69	+33.91
Юань	495.40	480.01	+15.39

27.3 Хүүгийн түвшний эрсдэл

ХЭСӨГ ТРЕЙД ХК

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн Санхүүгийн Тайлангийн Тодруулга

Хүүгийн түвшний эрсдэл нь голдуу хөвөгч хүүтэй хадгаламж, зээлд тохиолдож болох хүүгийн түвшний ирээдүйд гарах өөрчлөлтийн хэлбэлзлийн эрсдэл юм. Хүүгийн түвшний эрсдэлийн удирдлагын зорилго нь санхүүгийн зардлыг хамгийн бага байлгах болон хүүгийн түвшний өөрчлөлттэй холбоотой тодорхой бус байдлыг бууруулахад чиглэдэг.

Хүүгийн түвшний өөрчлөлттэй холбоотойгоор хүлээх зах зээлийн эрсдэл нь голдуу Компанийн зээлтэй хамааралтай байдаг.

27.4 Үйл ажиллагааны эрсдэл

Компанийн санхүүгийн удирдлагын бодлого болон зарчим нь компанийн зээлжих дээд хязгаар, капиталын бүтэц, эргэлтийн хөрөнгийн удирдлага, хөрвөх чадварууд дээр санхүүгийн харьцаануудын зохистой түвшинг тогтоох замаар санхүүгийн болон үйл ажиллагааны шилдэг арга туршлагыг нэвтрүүлэхийг зорилго болгодог байна. Мөн түүнчлэн зорилтот ашигт ажиллагаа, өөрийн хөрөнгийн өгөөжийн түвшинг тогтоохдоо зах зээлийн нөхцөл байдал болон зорилтот салбарын онцлогийг харгалзан үздэг.

Санхүүгийн тогтвортой байдлыг хангахын тулд Компанийн хөрөнгө оруулалт болон тогтоосон санхүүгийн харьцаануудыг тодорхой түвшинд хангаж байх хэмжээнд өөрсдийн бизнесийн төлөвлөгөө болон үйл ажиллагааны төсвийг боловсруулж, хэлэлцэн хэрэгжүүлдэг. Түүнчлэн, санхүүгийн харьцаануудын гүйцэтгэлийн биелэлт нь жилийн гүйцэтгэлийн үнэлгээний системд багтсан ба гүйцэтгэх удирдлагын багийн гүйцэтгэлийн үнэлгээ болон тэдний цалингийн хувьсах бүрэлдэхүүн хэсэгт (урамшуулал цалин) чухал ач холбогдолтой. Компанийн санхүүгийн удирдлагад ашиглагддаг хамгийн түгээмэл санхүүгийн харьцаанууд нь:

- Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа = Эргэлтийн хөрөнгө/Богино хугацаат өр төлбөр;
- Зээл/Хүү, татвар, элэгдэл, хорогдлын өмнөх ашиг (ХТЭХӨА);
- Эргэцийн харьцаа, хоног (авлага, бараа материал болон өглөг);
- Зээлийн үйлчилгээ хийх чадварын харьцаа = Чөлөөт мөнгөн урсгал/Зээлийн үйлчилгээний дүн;
- Өгөөжийн дотоод норм;
- Ашигт ажиллагааны зорилтот түвшин. ХТЭХӨА маржин, татварын дараах ашгийн маржин.

Хөсөг Трейд ХК нь зорилтот хөрөнгө оруулалтын өгөөжийг бий болгохын зэрэгцээ, компанийн хэмжээнд эрсдэлийг хамгийн бага хэмжээнд байлгахын тулд эрсдэлийн иж бүрэн цогц удирдлагын системийг бий болгохоор зорин ажиллаж байна.

28 Капиталын удирдлага

Компанийн капиталд хөрөнгө удирдлагын зорилгоор, хөрвөх нөхцөлтэй хувьцаа, хувьцааны урамшуулал болон эздийн өмчид хуваарилагдах бусад бүх капиталын нөөцийг оруулна. Компанийн хөрөнгийн удирдлагын үндсэн зорилго нь өөрийн бизнесийг дэмжих ба хувь нийлүүлэгчдийн хөрөнгийн үнэ цэнийг нэмэгдүүлэхэд оршино.

Компанийн өрийг өмчид харьцуулсан харьцааг тайлант хугацааны эцэст илэрхийлбэл:

(Мянган төгрөгөөр, өрийн харьцаанаас бусдаар)	2022.12.31	2023.12.31
Нийт өр*	393,096.5	501,490.4
Нийт эздийн өмч	901,503.6	776,061.3
Өрийн харьцаа	43.6%	64.6%

* Өр нь нийт татварын өр, нийт бусад өглөгийг хамруулсан.

ХЭСӨГ ТРЕЙД ХК

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн Санхүүгийн Тайлангийн Тодруулга

29 Холбоотой талууд

29.1 Хувьцаа эзэмшигчид болон компанийн удирдлага

Компанийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилд холбоотой талуудын хамаарал болон хийгдсэн ажил гүйлгээ байдалтай байна.

Хувьцаа эзэмшигчид	Харьяалал	Харилцан хамаарал	Холбоотой гүйлгээ
О.Дамжин	Монгол улс, Иргэн	Хувьцаа эзэмшигч	-
С.Жавзан-Орлом	Монгол улс, Иргэн	Хувьцаа эзэмшигч	-
Эй Ди Эм Эм Ди ХХК	Монгол улс, ААН	Хувьцаа эзэмшигч	-
Д.Бадам	Монгол улс, Иргэн	Хувьцаа эзэмшигч	-
Г.Маргад	Монгол улс, Иргэн	Хувьцаа эзэмшигч	-
Бусад	Иргэд, аж ахуйн нэгж	Хувьцаа эзэмшигч	-

29.2 Холбоотой талуудтай хийгдсэн ажил гүйлгээ:

Ногдол ашигтай холбоотой ажил гүйлгээ гараагүй байна.

Хувьцаа эзэмшигч	Хувьцааны тоо	Нэгж хувьцаанд ногдох ашиг /төгрөгөөр/	Зарласан ногдол ашиг /төгрөг/	Суутгуулсан ХХОАТ 5% /төгрөг/	Хүлээн авсан ногдол ашиг /төгрөг/
О.Дамжин	2,338	-	-	-	-
С.Жавзан-Орлом	51,974	-	-	-	-
Эй Ди ЭмЭм Ди ХХК	96,357	-	-	-	-
Д.Бадам	88,118	-	-	-	-
Г.Маргад	53,916	-	-	-	-
Бусад	3,090	-	-	-	-
ДҮН	295,793				

29.3 Бусад холбоотой талууд

Бусад холбоотой талуудад хувьцаа эзэмшигчид болон тэдний гэр бүлийн гишүүд болон гишүүдтэй холбоотой байгууллагууд, компанитай адил нэг захирал эсвэл гол удирдлагатай байгууллагууд, захирал болон гол удирдлага мөн тэдгээрийн гэр бүлийнхэнтэй холбоотой байгууллагууд хамаарна.

30 Үүрэг хариуцлага ба болзошгүй зүйлс

30.1 Хууль, эрх зүй

Компани нь бизнесийн ердийн үйл ажиллагааны явцад ч хуулийн аливаа зарга маргаан болон гомдолтой холбогдож болно. Хэрэв аливаа зарга маргаан, гомдол гарснаас ямар нэгэн үүрэг хариуцлага үүсвэл энэ нь Компанийн ирээдүйн үйл ажиллагааны үр дүн болон санхүүгийн байдалд материаллаг сөрөг нөлөө үзүүлэхгүй гэдэгт удирдлага итгэлтэй байна.

31 Тайлангийн дараах үйл явдал

Удирдлага нь санхүүгийн тайланд нөлөөлөхүйц тайлант хугацааны дараа гарсан бусад үйл явдал байхгүй гэж үзэж байна.